

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ АСАН Ж.ҮНЭНБАТ: БАРААНЫ ҮНЭ НЭМЭГДВЭЛ ЦАЛИН НЭМСНИЙ ХЭРЭГГҮЙ

Монгол банкны ерөнхийлөгч асан Ж.ҮНЭНБАТААС дараахь асуултуудад хариулт авлаа.

-Манай улсын ДНБ-ий өсөлт 17,8 хувьтай гарсан гэж хамтарсан Засгийн газрын гишүүд бахархаж байгаа. Төсөв анх удаа их наяд төгрөгийн ашигтай гарсан ч гэдэг. Үүнийг хэр бодитой тоо гэж та харж байна вэ?

-Уул уурхай түүнтэй хамаарах үйлчилгээн дээр суурилсан эдийн засгийн өсөлт гарч байгаа, нөхцөл байдал хэвээр үргэлжилбэл цаашид ч эдийн засгийн өсөлт тодорхой хугацаанд гарсаар байх болов уу. Энэхүү эдийн засгийн өсөлтийг ирээдүйд чиглэсэн тогтвортой өсөлтболгоход төсвийн бодлого чиглэх учиртай. Төсвийн тогтвортой байдлыг хангах хууль тогтоомж хэрэгжих бололцоо хэр зэрэг байна вэ, Хөгжлийн банк гэх мэт байгууллагын үйл ажиллагаа нь үүнийг тойрох арга зам уу, эрүүл мэнд, боловсрол, дэд бүтэц зэрэг улсаас өөрөөс нь хамаардаг зүйлдээ илүү анхаарч, хувийн секторын ажиллах нөхцөл бололцоог сайжруулсан бодлого хэрэгжиж байна уу, хориг саад учруулсан хэвээр байгаа юу зэрэг асуултууд хариулт шаардсаар байгаа.

-Монгол Улс өмнө нь төсвийн цоорхойг нөхөхийн тулд тодотгол хийдэг байсан бол энэ жил эдийн засаг, уул уурхайн салбарын өсөлттэй холбоотойгоор өөрчлөлт хийж байна гэж тайлбарлаад байна. Энэ нь бас л урд хормойгоороо хойд хормойгоо нөхөж байгаа явдал биш үү. Дээрх тодотгол нь нөгөө л цалин хөлс болон тэтгэврийг нэмэхтэй холбоотой мэт харагдаад байна. Таны бодол..?

-Тодотголыг системтэйгээр хийдэг манай орны хувьд төсвийн хариуцлага, сахилга бат, хүлээлт ямар байх нь ойлгомжтой. Уул уурхайн салбар ийм нөлөөтэй байгаагүй үед ч тодотгол хийсээр ирсэн түүхтэй. Эдийн засгийн өсөлт төсвийг томруулж байгаатай маргах юм алга. Гэхдээ үүнийг ямар хэмжээнд хаашаа зарцуулж байна гэдэгт анхаарах ёстой.

-Намууд, УИХ-ын гишүүд төрийн албан хаагчийн цалинг гурав дахин нэмэгдүүлэх амлалтдаа хүрэхэд сонгуулийн өмнөх хагас жил хүрэлцэхгүй, хөрөнгө мөнгө ч хэцүүдэх биз. Гэхдээ одоо тэдний цалинг 53 хувиар нэмэхээр ярьж байна. Үүнийг дагаад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өсөхгүй байх, өслөө гэхэд хувийн хэвшлийнхэн үүнд чирэгдэхгүй байх ямар арга зам байх бол?

-Цалинг нэмэхтэй уялдаад хөдөлм өрийн бүтээмж, үр ашиг дээшлэх асуудлыг хамт тавих ёстой. Тэрийг яаж хэмжих вэ. Зөвхөн энэ ч биш. Яваандаа эдийн засаг өсөөд хүмүүсийн цалин нэмэгдээд дунджаар орлогын төвшин нэлээд ахилаа гэж бодъё. Одоо 1000 төгрөгөөр авдаг байсан зүйлээ 1500 эсвэл 2000

төгрөгөөр авдаг болбол цалин нэмсний хэрэг юу байна вэ. Хэрэглээний бараа ч ингэтлээ цалингаа дагаж өсөхгүй байх, харин бусад активын хувьд магадгүй шүү.

-Олон улсын байгууллагууд манай улсыг буурай орноос дундаж орлоготой орон гэсэн зэрэглэлд оруулсан. Гэтэл ажилгүйдэл, ядуурал улам нэмэгдээд байх шиг. Иргэн хүний хувьд ямар үнэлэлт дүгнэлттэй байна вэ?

-Олон улсын байгууллагууд нэг хүнд ногдох ДНБ гэх мэт үзүүлэлтийг чиг баримжаа болгодог. Орлого нь яг ингэж тэнцүү хуваагддаггүй учраас л гол зовлон болдог. Тэгэхээр энэ үзүүлэлт бодлого барьдаг хүмүүст нэг ч их ач холбогдолтой зүйл биш байх.

-Монгол Улсын эдийн засаг тогтвортой өсч байна. Цаашид тогтвортой хадгалагдана, өснө гэсэн таамаг байгаад байх юм. Таныхаар энэ төлөв хэр бодитой байх бол?

-Би хэлсэн, нөхцөл байдал хэвээр үргэлжилбэл цаашид ч эдийн засгийн өсөлт тодорхой хугацаанд гарсаар байх болно.

-Томоохон ордууд дээр байгуулах гэрээ, сонгон шалгаруулалт сонгуулийн урьдчилсан шоу болох вий гэж манай эдийн засагчид болгоомжилж байна. Таны хувьд энэ талаар ямар санал бодолтой, магадгүй болгоомжлолтой байна вэ?

-Аль болохоор улс төрөөс хол, Засгийн газрын нөлөө хязгаарлагдмал байдлаар хэрэгжих, эсвэл сонгон шалгаруулалтыг гэрээний үндсэн дээр хувийн сектор зохион байгуулж байвал илүү үр дүнтэй болно гэж үзэж байна.

-Саяхан АХБ-нд Монгол Улс элсэж, холбоо тогтоосоны 20 жилийн ойгоор өндөр дээд хэмжээний албаны хүмүүс манайд ирсэн. Тэд уул уурхайгаас орж ирэх хөрөнгөө зөв зохистой зарцуулах, хуваарилах талаар чухал санал зөвлөмж өгч байсан. Манайхан Дэлхийн банкны үгийг ч сонсохоо больчихсон юм биш үү. Гэхдээ мөнгө хөрөнгөтэй болж байгаа энэ үед Төв банк мөнгөний ямар бодлого баримталбал зохистой вэ. Эдийн засагч, Монголбанкны ерөнхийл өгч байсан хүний хувьд өөрийн бодлоо хуваалцана уу?

-Харин ийм их мөнгө хөрөнгөтэй өсөв байгаа учраас мөнгөний бодлогын үр нөлөө хязгаарлагдмал болоод байна. Гэхдээ төсөв мөнгөний бодлогын уялдаа нь төсвийн тогтвортой байдлын санаачилга яв цав хэрэгжээд ирэхийн цагт илүү утга төгөлдөр болох байх.

Д.МӨНХЖАРГАЛ